



ana rewakowicz

Interdisciplinary artist
Born in Poland 1969, lives and works in Montreal, Canada

As a person who has moved from one culture to another and lived through cultural and language adaptations (growing up as a Ukrainian in Poland, moving to both English and French Canada via Italy, travelling and living in different countries), I have been interested in the notions of identity, belonging and living in a culture and society of global and technological developments. In a world where the distance between far and near has shrunk, being 'abroad' no longer means being away from home(land). Through the exploration of the theme of nomadism, as a symbol of movement, multidimensionality and adaptation, I reflect on the transient life of today.

As John Berger said: "Home is represented not by a house, but by a practice or set of practices. Everyone has his own." And I have developed my own. Since 2000, I have been working with inflatable objects, exploring these concerns through clothing and habitation. In contrast to the permanent mass of monumental sculpture and architecture, my costumes and structures are air-filled, mobile, and concerned with the places and people that activate them. Incorporating new materials and technology, I build devices that create intimate - yet paradoxically public - experiences, and fashion them, based on function and travel, for the contemporary nomad and the displaced.

My artwork is inspired by Buckminster Fuller's concept of Synergetics, which is a system of thinking that encompasses a multi-faceted approach towards life and design, seen not as a fragmented concept applied to various professional



practices but as a creative process that lies at the heart of any human activity. Fuller's exploration of the interrelationship and connectivity between geometric modelling, nature and humans provides a method and a philosophy for problem solving, and therefore has applications in all areas of human endeavour. I am deeply concerned with the integrity of materials, processes and ideas, and I make objects that propose an alternative way of living through the process of bringing producer and consumer back into a human(e) relationship. In my work, it is not necessarily the object that is the main focus of attention but the action I perform with this object. It is as if the object is a pretext for social exchange. Through this method, I reflect on both the most fundamental human need for safety and wellbeing, and the growing complexities of being an individual in the increasingly intense world of global communication and simultaneity.

When visiting Mongolia in 2008, I was impressed by the inventiveness of the people who live with limited resources. It was not uncommon to see solar panels and satellite dishes attached to yurts in the middle of nowhere, or whole families travelling on a single motorbike carrying large loads on bumpy dirt roads. Inspired by this experience, and with the assistance of students from the Mechanical Engineering Department at McGill University in Montreal, we created the SR-Hab (Socially Responsive Habitat) prototype - a mobile, self-sustainable bicycle unit for urban commuting and dwelling. The main objective of this project was to look into green sources of energy such as solar, wind and kinetic movement and to develop inventive solutions for mobile, sustainable living on a small scale, applicable not only to Mongolia, but also to the transient culture of most Western countries. The first prototype, which featured in the Bare House exhibition, combines a commuter bicycle with a habitat that can sustain basic living 'off the grid'. The electricity generated by the user through dynamos and solar panels powers the appliances within the habitat such as lights, a laptop, an iPod and cooking equipment.

The SR-Hab builds on the idea of living 'off the grid' first developed in the SleepingBagDress prototype 2 produced during a three-month residency at Foam Laboratory in Brussels, Belgium in 2004. This work was inspired by the legacy of Archigram, a radical British architecture practice of the 1960's that investigated the relationship between cities and new technologies; regarding fun, play and pleasure as their projects' rationale. The SleepingBagDress prototype involves a multipurpose kimono-dress that when inflated, changes into a cylindrical container inhabitable by one or two people. This prototype operates on a small computer fan powered by rechargeable batteries, charged by a solar panel incorporated into the dress. The SleepingBagDress looks at the portability and self-sustainability of a wearable cell, comfortable as both a dress and as a temporary shelter. It was used in walking performances and public interventions in Mexico City (Mexico), Toulouse (France), Brussels (Belgium) and as part of the 2004 International Symposium of Electronic Art



(ISEA2004) in Tallinn, Estonia. In Mexico City, I made appointments with different people to go to their favourite places in the city and accommodated them in the dress. Inside, I conducted short interviews, in a language of their choice, collecting personal stories about these places and people's idea of belonging. The idea of a portable home brought to the fore questions about social relations and different ways in which we negotiate and experience the private and public.

SR-Hab and SleepingBagDress do not intend to provide practical solutions but offer a platform for a conversation about our experiences of living in a globalised world.

Supported by Canada Council for the Arts and the Conseil des arts et des lettres du Quebec

[text AR]



Ана Ревакович

Уран бүтээлч

Тэрээр 1979 онд Польш улсад бөгөөд одоо Канад улсын Монреал хотод ажиллаж, амьдарч байгаа.

Би өөрөө нэг соёлоос нөгөө соёл рүү нүүж, янз бүрийн соёлын ба хэл ярианы орчинд дасан зохицож амьдарч ирсэн болохоор, (Польш улсад Украин хүн болон өссөн ба, Италиар дамжиж Канад руу нүүсэн) бие хүний тухай, дэлхий дахины соёлын болон технологийн хөгжилд харъяалагдах болон тэр дунд амьдрах ойлголтуудын тухай сонирхож ирсэн болно. Одооны дэлхий ертөнцөд *хол* болон *ойрын* зай ойртсон ба, 'гадаадад байна' гэдэг нь гэрээс (эх газраас) хол байна гэсэн ойлголт биш болсон юм. Би өнөөгийн түр зуурын шилжилтийн маягтай амьдралыг, нүүдэлчний соёл буюу номадизм-ын сэдэвтэй холбон, түүнийг хөдөлгөөн, олон-хэмжээст-чанар ба дасан зохицолтын бэлгэ тэмдэг гэж авч үзэн судалдаг.

Жон Бергер: "Гэр орон нь дан ганц байшингаар биш дадлага зуршил ба тэдгээрийн цогцоор илэрхийлэгддэг. Хүн бүр өөрийн гэсэн дадлага зуршилтай." гэж хэлсэн байдаг. Үүнээс үүдэн би өөрийн гэсэн дадлага зуршлыг хөгжүүлсэн юм. 2000 оноос би эдгээр ойлголтуудыг хувцаслалт болон аж амьдрахуйтай холбож, хийгээр дүүргэдэг материалуудыг ашиглан бүтээл хийж ирсэн. Байнгын тогтмол масстай хөшөө баримал болон уран барилгаас миний бүтээлүүдийн ялгаа тал бол тэдгээр нь зөөврийн чанартай, агаараар дүүргэсэн хувцаснууд болон биетүүд ба тэднийг идэвхжүүлэгч хүчин зүйлүүд болох газрууд болон хүмүүсийн тухай өгүүлдэг юм. Би шинэ материалууд

болон технологийг ашиглан, орчин үеийн нүүдэлчинд зориулан, жижиг хэмжээтэй боловч олон нийтэд тохируулсан, аялах боломжтой төхөөрөмжүүдийг бүтээдэг.

Миний бүтээл нь Букинминстр Фуллерийн *Synergetics* онолоос санаа авсан бөгөөд энэ нь амьдрал болон дизайнд чиглэсэн олон-талт хандлагыг оролцуулсан, төрөл бүрийн мэргэжлийн дадлагад хэрэглэгддэг хэсэгчилсэн биш ойлголт бөгөөд хүний бүхий л үйл ажиллагааны төвд орших үйл явцыг тодорхойлсон системчилсэн сэтгэлгээ юм. Фуллерийн хүн, байгаль болон геометрийн моделийн хоорондох холбоос болон дотоод харилцааны тухай судалгаа нь асуудал шийдвэрлэх аргачлал ба философи *г* бий болгож байгаа бөгөөд энэ нь хүний чармайлтын бүхий л талтай хамааралтай юм.

Би материалууд, үйл явцууд болон санаануудын мөн чанарыг их анхаардаг бөгөөд, би бүтээгч ба хэрэглэгч хоёрыг хамтад нь хүмүүн (лэг) харилцаанд оруулж, өөр маягаар амьдрах аргыг санал болгосон биетүүдийг бүтээдэг. Миний бүтээлд, биетүүд нь гол биш ба тэр биетийг ашиглан хийх миний өөрийн үйлдэл нь илүү чухал юм. Энэ нь яг тэр биет нь нийгмийн харилцаанд орох шалтаг мэт. Энэ аргачлалаар, би хүний үндсэн хэрэгцээнүүд болох аюулгүй байдал ба эрүүл энх байх хүслүүд мөн глобалчлагдсан дэлхий ертөнцийн эрчимжиж буй холбоо харилцаан дунд бие хүн байх түвэгтэй байдлын тухай эргэцүүлдэг.

2008 онд би Монголд айлчлах явцдаа, хязгаарлагдмал нөөцийг ашиглан амьдарч байгаа хүмүүсийн зохион бүтээлч байдлыг хараад их сэтгэгдэл төрсөн юм. Хиймэл дагуулын антенна юм уу нарны энергээр ажилладаг хавтан байрлуулсан айл гэрүүд болон гэр бүлээрээ нэг мотоцикл дээр сууж бас дээрээс нь том ачаатайгаар донсолгоотой замаар аялаж байхыг би олонтаа харсан. Үүнээс санаа аван, Монреал (Канад улс) хотын МкГиллийн Их Сургуулийн инженерийн факультетийн оюутнуудын туслалцаатайгаар, бид хотын орчинд аялахад тохируулсан, SR-Hab нэртэй хөдөлгөөнт-төхөөрөмж болох унадаг дугуйг бүтээсэн юм.

Энэ төслийн гол зорилго нь ногоон эрчим хүчний эх үүсвэрүүд болох нар болон салхийг ашиглан, ганцхан Монголд биш барууны орнуудын хүмүүсийн хөдөлгөөнт амьдралд зориулсан шийдлүүдийг бүтээхэд байсан юм. Энэ нэгдүгээр туршилтын дугуй нь Нүцгэн Байшин үзэсгэлэнд тавигдсан. Энэ дугуйг унаж байгаа хүний үйлдэл нь цахилгаан үүсэх ба тэр цахилгаанаар дугуй дээрх гэрэл, компьютер, iPod болон хоол хийх төхөөрөмжүүдийг ажиллуулна.

SR-Hab-ы бүтээлийн 'цахилгаан зүтгүүр'-ийг ашиглаж амьдрах санаа нь 2004 онд Бельги улсын Бруссель хотод байрладаг FoAM (уран бүтээлчдийн нэгдэл) дээр 3 сарын хугацаанд уран бүтээлчээр ажиллаж байхдаа бүтээсэн *SleepingBagDress* нэртэй бүтээлээс урган гарсан



SleepingBag Dress, walking performance, Tallinn, video stilli 2003



SleepingBag Dress, walking performance, Mexico City, video still, 2003

юм. *SleepingBagDress* нь 1960-аад оны Их Британий уран барилгын Аркиграм нэртэй дадлагаас санаа авсан ба энэ судалгаа нь тоглоом ба зугааг голчлон, хотууд болон шинэ технологиудын хоорондох холбоог судалсан болно. *SleepingBagDress* нь олон янзаар ашиглах боломжтой кимоно-хувцас бөгөөд түүнийг агаараар дүүргэсэн үед нэг юм уу хоёр хүн багтах цилиндр хэлбэртэй чингэлэг болж хувирдаг болно. Энэ бүтээл нь тухайн кимоно-хувцсан дээр байрлуулсан нарны эрчим хүчээр цэнэглэгддэг баттерейнуудаар ажилладаг.

SleepingBagDress нь зөөврийн чанартай, өмсөж боломжтой батерейн хувцас бөгөөд түр зуурын оромж болон хувцас маягаар хэрэглэж болох юм. Би энэ хувцсыг өмсөж Мексико (Мексик улс), Бруссель (Бельги улс), Тулуйз (Франц улс) хотуудад болон 2004 оны Эстони улсын Талинн хотод зохиогдсон Олон Улсын Электроник Урлагийн Симпозиумын хүрээнд перформансуудыг хийсэн. Би Мексико хотод хүмүүсийг тухайн хотын дуртай хэсэг рүү очихыг асуугаад, тэднийг өөрийн бүтээсэн зөөврийн чингэлэгт орж суухыг урьсан. Тэр зөөврийн чингэлэг дотор би хүмүүсээс ярилцлага авч, тэдний хувийн түүх ба тухайн хотын хэсгүүдэд харъяалагдах сэтгэгдлийг цуглуулсан юм. Зөөврийн гэр орны тухай санаа нь нийгмийн хүрээнд бидний олон нийтийн болон хувийн харилцаанд олон янзын замаар хэлэлцээ хийдэг тухай асуудлуудыг гаргаж ирдэг болно.

SR-Hab болон *SleepingBagDress* нь өдөр тутмын амьдралд зориулсан шийдвэрүүдийг олоход биш харин бидний глобалчлагдсан дэлхийд амьдарч байгаа тухай ярилцлагыг үргэлжлүүлэхэд зориулсан талбарыг бий болгоход оршиж байгаа юм.

Төсөл нь Канадын Соёл Урлагийн Консул болон Квебекийн Урлагийн Консулын туслалцааг хүлээж авсан болно.